

**“АЛТАНБУЛАГ ЭКСПО-2016”  
ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ,  
ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ  
ТАНИЛЦУУЛГА**



МОНГОЛ УЛС, СЭЛЭНГЭ АЙМАГ, АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮС

**EXPO 2016**  
Altanbulag **freezone**

**МОНГОЛ УЛС,  
СЭЛЭНГЭ АЙМАГ,  
АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮС**  
2016.05.21-22

УТАС/ФАКС: (976)-51-261430

ГАР УТАС: (976)-99051533

ЦАХИМ ХУУДАС: [HTTP://WWW.ALTANBULAG.GOV.MN/](http://WWW.ALTANBULAG.GOV.MN/)

ЦАХИМ ХАЯГ: [EXPO2016@ALTANBULAG.GOV.MN/](mailto:EXPO2016@ALTANBULAG.GOV.MN/)

# “АЛТАНБУЛАГ ЭКСПО-2016” ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ ТАНИЛЦУУЛГА



“АЛТАНБУЛАГ ЭКСПО-2016” Олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэн худалдааны зорилго нь Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн болон хувийн хэвшил, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн төлөөлөл, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хамтран чөлөөт бүсийн хөгжлийн асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх нийтлэг ойлголцлыг бий болгоно.

Энэхүү олон улсын чуулга уулзалт нь шинэчлэн батлагдсан “Чөлөөт бүсийн тухай” хуулийн хүрээнд хийгдэж байгаа анхны томоохон арга хэмжээ бөгөөд эдийн засгийн коридор байгуулах, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хил дамнасан тээврийг хөнгөвчлөх, дэд бүтцийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зэрэг асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлнэ.

## **ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД:**

### **НЭГ. ДЭЛХИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЧИГ ХАНДЛАГА, МОНГОЛЫН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Олон улсад чөлөөт бүсийг хөгжүүлсэн сайн туршлага, чөлөөт бүсийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж тэдгээрт үнэлэлт дүгнэлт өгч нэгдсэн нэг ойлголтод хүрнэ.

### **ХОЁР. “ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ” ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Чөлөөт бүсийн тухай хуульд тусгагдсан чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжид үзүүлэх, хөнгөлөлт чөлөөлөлт, давуу талыг танилцуулан хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр санал солилцоно.

### **ГУРАВ. ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ**

Монгол Улсын тээвэр логистикийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, худалдаа, үйлчилгээ болон бизнес эрхлэх бүс нутгийн хэмжээний тээвэр, агуулахын оновчтой, зардал багатай тогтолцоог бий болгох арга замыг тодорхойлно.

# “АЛТАНБУЛАГ ЭКСПО-2016” ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ ТАНИЛЦУУЛГА



## **ДӨРӨВ. ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ**

Чөлөөт бүсээр дамжуулан гадаад зах зээлд хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа мах махан бүтээгдэхүүнийг экспортлоход тулгарч буй хүндрэлүүд /хил, гааль, татварын орчин, мэргэжлийн хяналт, хорио цээр, лаборатори, мал эмнэлэг гэх мэт/ т үүнийг шийдвэрлэх арга замыг олон талын төлөөллүүдийг оролцуулан хэлэлцэнэ.

## **ТАВ. НООС НООЛУУР, АРС ШИРНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ**

Хөнгөн болон жижиг, дунд үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд борлуулах салбарыг байгуулах боломжийн талаар хэлэлцүүлэг өрнүүлж шийдэлд хүрнэ. Ялангуяа ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүнийг экспортлох, тэдгээрийг сурталчлан таниулах, татварын хөнгөлөлтийг үзүүлэх, саадгүй нэвтрэх олон шат дамжлагыг бууруулах зэрэг асуудлаар санал солилцоно.

## **ЗУРГАА. НИЙТИЙН ХООЛ, ЗОЧИД БУУДАЛ**

Нийтийн хоол, ресторан, зочид буудлын салбарт хамтран ажиллах боломжийн талаар хэлэлцэж бизнес эрхлэгчид, үйлчилгээний байгууллагууд харилцан олон улсын чанар стандартад нийцсэн бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх, сүлжээ байгуулах төслүүдийг танилцуулна.

## **ЧУУЛГАНД ОРОЛЦОГЧДЫН ТУХАЙ:**

УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд, Орон нутгийн удирдлагууд, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл, гадаад улсын элчин сайдууд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид, Аж ахуй нэгжүүд, эрдэмтэн судлаачид зэрэг 2000 гаруй зочид, төлөөлөгчид оролцоно.

## **ЧУУЛГАНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД:**

АЖ ҮЙЛДВЭРИЙН ЯАМ, ГАДААД ХЭРГИЙН ЯАМ,  
АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА,  
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗДТГ, МОНГОЛ ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ,  
“АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛ.